



ТӨРСНИЙ БҮРТГЭЛ

Эцэг, эх, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл эрх бүхий байгууллагын төлөөлөгч хүүхэд төрсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор дараах баримт бичгийг бүрдүүлж, төрсний бүртгэлд бүртгүүлнэ.

Гэрлэсний бүртгэлтэй иргэний бүрдүүлэх материал

- Эцэг, эхийн иргэний үнэмлэх
- Хүүхэд төрсөн тухай эмнэлгийн байгууллагын магадлагаа буюу СТ-4 маягт
- Эцэг, эхийн гэрлэсний гэрчилгээ

! Эцэг, эх нь гэрлэсний бүртгэлд бүртгүүлсэн бол хүүхдийн эцэг, эхийн хэн нэг нь улсын бүртгэлд бүртгүүлж болно.

! Гэрлэсний бүртгэлд бүртгүүлсэн эцэг, эхийн хэн нь ч ирж бүртгүүлэх боломжгүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлнэ.

Гэрлэсний бүртгэлгүй иргэний бүрдүүлэх материал

- Эхээр овоглох бол
- Эхийн иргэний үнэмлэх
- Хүүхэд төрсөн тухай эмнэлгийн байгууллагын магадлагаа буюу СТ-4 маягт

- Эцгээр овоглох бол
- Эцэг, эхийн иргэний үнэмлэх
- Тус тусдаа гаргасан өргөдөл
- Хүүхэд төрсөн тухай эмнэлгийн байгууллагын магадлагаа буюу СТ-4 маягт

! Гэрлэсний бүртгэлд бүртгүүлээгүй эцэг, эх хүүхдээ эцгийн нэрээр овоглох бол хүүхдийн эцэг, эх хоёул биеэр ирнэ.

! Эцэг, эхийн хэн нэг нь ирэх боломжгүй бол өргөдлөө нотариатаар батлуулна



Засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй өөрт ойр байрлах Улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ.



QR код уншуулан үйлчилгээний нэгжүүдийн хаяг байршлыг харна уу



ГЭРЛЭСНИЙ БҮРТГЭЛ

Гэрлэхийг хүсэгчид дараах баримт бичгийг бүрдүүлж, гэрлэсний бүртгэлд **өөрийн биеэр** бүртгүүлнэ.



Бүрдүүлэх материал

- ▶ Тус тусдаа гаргасан өргөдөл
- ▶ Гэрлэхийг хүсэгчдийн иргэний үнэмлэх
- ▶ Гэрлэхийг хүсэгчдийн эрүүл мэндийн шинжилгээний бичиг (Дох, Сэтгэц, Сүрьеэ)

- ❗ 18 нас хүрсэн хүнийг гэрчээр оролцуулна
- ❗ Үйлчилгээний хураамж 2500 төгрөг тушаасан баримт



Төрийн банк 106030085769
Гэрэгэ киоск ашиглан
тушаах боломжтой

Улсын бүртгэлийн
нэгж



Засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй өөрт ойр байрлах Улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ.



QR код уншуулан
үйлчилгээний
нэгжүүдийн хаяг
байршлыг харна уу



ГЭРЛЭЛТ ДУУСГАВАР БОЛСНЫ БҮРТГЭЛ

ГЭРЛЭЛТЭЭ ЗАХИРГААНЫ ЖУРМААР ЦУЦЛУУЛАХ

Гэрлэлтээ захиргааны журмаар цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн иргэн дараах баримт бичгийг бүрдүүлж, гэрлэлт дуусгавар болсны бүртгэлд өөрийн биеэр бүртгүүлнэ.

- Тус тусдаа гаргасан өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Гэрлэлтийн гэрчилгээ

❗ Тус тусдаа гаргасан өргөдөлд эд хөрөнгийн маргаангүй болон, төрсөн буюу үрчилж авсан 18 хүртэлх насны хүүхэдгүй, гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрснөө дурьдсан байна.

❗ Гэрлэлтээ захиргааны журмаар цуцлуулж байгаа иргэн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирэх боломжгүй бол өргөдлийг нотариатаар гэрчлүүлсэн байна.

❗ Үйлчилгээний хураамж 2500 төгрөг тушаасан баримт

ГЭРЛЭЛТЭЭ ШҮҮХИЙН ЖУРМААР ЦУЦЛУУЛАХ

Гэрлэлтээ шүүхийн журмаар цуцлуулсан иргэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор дараах баримт бичгийг бүрдүүлж, иргэний улсын бүртгэлд бүртгүүлнэ.

- Иргэний үнэмлэх
- Гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэр
- Гэрлэлтийн гэрчилгээ

❗ Үйлчилгээний хураамж 2500 төгрөг тушаасан баримт



Төрийн банк 106030085769
Гэрэгэ киоск ашиглан
тушаах боломжтой

Улсын бүртгэлийн
нэгж



Засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй өөрт ойр байрлах Улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ.



QR код уншуулан
үйлчилгээний
нэгжүүдийн хаяг
байршлыг харна уу



Хүүхэд үрчлэн авахыг хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлж, хүүхдийн оршин суугаа газрын сум, дүүргийн Засаг даргад өөрийн биеэр хандана.

Улсын бүртгэлийн байгууллагад



- Сум дүүргийн, Засаг даргын хүүхэд үрчлүүлэхийг зөвшөөрсөн тухай захирамж
- Үрчлэн авч байгаа эцэг, эхийн иргэний үнэмлэх

❗ Үйлчилгээний хураамж 2500 төгрөг тушаасан баримт

Төрийн банк 106030085769
Гэрэгэ киоск ашиглан
тушаах боломжтой

Хүүхдийн оршин суугаа сум, дүүргийн Засаг даргад



- Өргөдөл /Нотариатаар гэрчлүүлсэн байна/
- Хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн зөвшөөрөл /Нотариатаар гэрчлүүлсэн байна/
- Үрчлэн авагч болон үрчлүүлж байгаа эцэг, эхийн иргэний үнэмлэх
- Гэрлэсэн бол гэрлэлтийн гэрчилгээ
- ❗ Гэр бүлийн тухай хуулийн 55.2, 55.3, 55.4-т заасан зөвшөөрөл

Улсын бүртгэлийн нэгж



Хүүхдийн оршин суугаа газрын улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ




QR код уншуулан үйлчилгээний нэгжүүдийн хаяг байршлыг харна уу



Иргэний нас барсныг нас барагчийн 18 нас хүрсэн гэр бүлийн гишүүн, эсхүл эцэг, эх, эсхүл төрөл садангийн хүний аль нэг нь нас барагчийн иргэний үнэмлэх болон доор дурдсан баримт бичгийн аль тохирохыг бүрдүүлж улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.



- Иргэний үнэмлэх
- Иргэний нас барсан тухай эмнэлгийн магадлагаа (АМ-7 маягт)

 Нас барсан иргэнийг аймаг, нийслэлд 3, сум, дипломат төлөөлөгчийн газарт 7 хоногийн дотор бүртгүүлнэ.

Улсын бүртгэлийн нэгж



Засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй өөрт ойр байрлах Улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ.



QR код уншуулан үйлчилгээний нэгжүүдийн хаяг байршлыг харна уу



ЭЦЭГ /ЭХ/ ТОГТООСНЫ БҮРТГЭЛ



Хүүхдээ төрсний бүртгэлд бүртгүүлснээс хойш гэрлэлтээ бүртгүүлсэн эцэг, эх хүүхдээ эцгийн овог, нэрээр бүртгүүлэх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, өөрийн биеэр бүртгүүлнэ.

- Эцэг, эхийн өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Гэрлэлтийн гэрчилгээ
- Хүүхдийн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх



Эцэг, эхийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр ирэх боломжгүй бол эцэг /эх/ тогтоолгох тухай өргөдлийг нотариатаар гэрчлүүлсэн байна.



Үйлчилгээний хураамж 2500 төгрөг тушаасан баримт



Хүүхдийн эцэг /эх/ болохыг шүүхээс тогтоосон бол эцэг /эх/ нь дараах баримт бичгийн аль тохирохыг бүрдүүлж, бүртгүүлнэ.

- Иргэний үнэмлэх
- Хүүхдийн төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх
- Эцэг, эх болохыг тогтоосон шүүхийн шийдвэр



Үйлчилгээний хураамж 2500 төгрөг тушаасан баримт



Төрийн банк 106030085769
Гэрэгэ киоск ашиглан
тушаах боломжтой

Улсын бүртгэлийн нэгж



Засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй өөрт ойр байрлах Улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ.



QR код уншуулан үйлчилгээний нэгжүүдийн хаяг байршлыг харна уу



ОВОГ, ЭЦЭГ /ЭХ/-ИЙН НЭР, ӨӨРИЙН НЭР ӨӨРЧИЛСНИЙ БҮРТГЭЛ



Иргэн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрээ өөрчлөх бол дараах баримт бичгийг бүрдүүлж, оршин суугаа газрын улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

18 НАСАНД ХҮРСЭН ИРГЭН ОВОГ, ЭЦЭГ / ЭХ/-ИЙН НЭР, ӨӨРИЙН НЭР ӨӨРЧИЛСНИЙ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ БОЛ



- Өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Гэрлэсэн бол гэрлэлтийн гэрчилгээ
- Хүүхэдтэй бол түүний төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх

⚠ Үйлчилгээний хураамж 2500 төгрөг тушаасан баримт

0-18 НАСНЫ ХҮҮХДИЙН ОВОГ, ЭЦЭГ /ЭХ/-ИЙН НЭР, ӨӨРИЙН НЭР ӨӨРЧИЛСНИЙ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ БОЛ



- Эцэг, эх, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл
- Төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх

⚠ Үйлчилгээний хураамж 2500 төгрөг тушаасан баримт

Төрийн банк 106030085769
Гэрэгэ киоск ашиглан
тушаах боломжтой

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЧАДАМЖГҮЙ ИРГЭНИЙ ОВОГ, ЭЦЭГ /ЭХ/-ИЙН НЭР, ӨӨРИЙН НЭР ӨӨРЧИЛСНИЙ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХ БОЛ



- Иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон бол шүүхийн шийдвэр
- Төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх

⚠ Үйлчилгээний хураамж 2500 төгрөг тушаасан баримт

Улсын бүртгэлийн нэгж



Оршин суугаа газрын улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ



QR код уншуулан үйлчилгээний нэгжүүдийн хаяг байршлыг харна уу



ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ БҮРТГЭЛ



Иргэн шилжин суурьшихдаа дараах баримт бичгийг бүрдүүлж, оршин суух газрынхаа улсын бүртгэлийн нэгжид 10 хоногийн дотор өөрийн биеэр бүртгүүлнэ.

- Иргэний үнэмлэх
- 16 нас хүрээгүй хүүхэдтэй иргэн оршин суух бол хүүхдийн төрсний гэрчилгээ
- Оршин суух газраа нотлох баримт бичиг
 - Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
 - Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ;
 - Нотариатаар гэрчлүүлсэн түрээсийн, захиалгын зэрэг гэрээ;
 - Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эсхүл эзэмшигчийн бичгээр гаргасан оршин суулгах тухай зөвшөөрөл;
- Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт

- ❗ Иргэн өөрийн үл хөдлөх эд хөрөнгө байгаа хаяг дээр шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэхийг зөвшөөрч байгаагаа дурдсан байна.
- ❗ Шилжин ирж байгаа иргэн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн нэр дээр байгаа хаяг дээр шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлэхийг хүссэн тухай хүсэлт.
- ❗ Иргэн өөрийн биеэр бүртгүүлэх боломжгүй тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан бүртгүүлж болно
- ❗ Нийслэлээс аймагт, Аймагас аймагт 2500 төгрөг, тэмдэгтийн хураамж 1000 төгрөг
Аймагас нийслэлд 5000 төгрөг, тэмдэгтийн хураамж 1000 төгрөг
Аймаг, нийслэл дотроо - 1500 төгрөг, тэмдэгтийн хураамж 1000 төгрөг

Төрийн банк 106030085769 | Гэрэгэ киоскоор тушаах боломжтой

Улсын бүртгэлийн нэгж



Оршин суугаа газрын улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ



QR код уншуулан үйлчилгээний нэгжүүдийн хаяг байршлыг харна уу



ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙН БҮРТГЭЛ



Монгол Улсын 16 нас хүрсэн иргэн анх удаа иргэний үнэмлэх авах, 25, 45 нас хүрсэн иргэн иргэний үнэмлэхээ солиулахад биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлд өөрийн биеэр бүртгүүлнэ.

16 НАСАНД ХҮРЧ ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ АНХ УДАА АВАХ

Зураг авхуулах бэлтгэлтэй ирэх



- Төрсний гэрчилгээ
- Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт

⚠ Үйлчилгээний хураамж 15000 төгрөг
Тэмдэгтийн хураамж 3300 төгрөг

25, 45 НАС ХҮРЧ ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХЭЭ СОЛИУЛАХ

Зураг авхуулах бэлтгэлтэй ирэх



- Иргэний үнэмлэх
- Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт

⚠ Үйлчилгээний хураамж 15000 төгрөг
Тэмдэгтийн хураамж 3300 төгрөг

ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХИЙГ ГЭЭСЭН, ҮРЭГДҮҮЛЭН ДАХИН АВАХАД



- Хүсэлт
- Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт

⚠ Үйлчилгээний хураамж 30000 төгрөг
Тэмдэгтийн хураамж 3300 төгрөг

ДҮР ТӨРХИЙН ӨӨРЧЛӨЛТ ОРЖ ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХЭЭ СОЛИХОД

Зураг авхуулах бэлтгэлтэй ирэх



- Дүр төрх өөрчлөлт орсон талаар эмнэлгийн тодорхойлолт
- Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт

⚠ Үйлчилгээний хураамж 30000 төгрөг
Тэмдэгтийн хураамж 3300 төгрөг

Төрийн банк 106030085769 | Гэрээг киоскоор тушаах боломжтой

Улсын бүртгэлийн нэгж



Засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй өөрт ойр байрлах Улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ.



QR код уншуулан үйлчилгээний нэгжүүдийн хаяг байршлыг харна уу



ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ



Монгол Улсын иргэн гадаад паспорт авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлж өөрийн биеэр бүртгүүлнэ

➤ Иргэний үнэмлэх

➤ 16-с доош настай бол төрсний гэрчилгээ, түүний хууль ёсны төлөөлөгчийн иргэний үнэмлэх

➤ Улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хөлс төлсөн баримт

❗ Өөрийн биеэр ирэх

❗ Өөрийн биеэр ирэх боломжгүй тохиолдолд Итгэмжлэл

❗ Улсын бүртгэгчээр гадаад паспортын зургаа авхуулж болно.

❗ Энгийн паспорт 40.000 ₮
(Үйлчилгээний хураамж 35.000 ₮
Тэмдэгтийн хураамж 5000 ₮)

Цахим паспорт 82.500 ₮

(Үйлчилгээний хураамж 77.500 ₮
Тэмдэгтийн хураамж 5000 ₮)



Төрийн банк 106030085769

Гэрэгэ киоск ашиглан тушаах боломжтой

Улсын бүртгэлийн нэгж



Засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүй өөрт ойр байрлах Улсын бүртгэлийн нэгжид бүртгүүлнэ.



QR код уншуулан үйлчилгээний нэгжүүдийн хаяг байршлыг харна уу